



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

「Үзлэг шалгалт зохион байгуулах тухай」

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.1 дэх заалтууд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 119 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, гэмт хэрэг, хэв журмын зөрчил, үер усны аюул, болзошгүй осол эндэгдлээс урьдчилан сэргийлэх, нийтийн эзэмшлийн зам талбайн орчны аюулгүй байдалд үзлэг шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үзлэг шалгалт зохион байгуулахад шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үзлэг шалгалтын удирдамжийг боловсруулан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар батлуулж мөрдөж ажиллахыг Ажлын хэсэг /Б.Гэрэлмаа/-т даалгасугай.

3. Үзлэг шалгалт зохион байгуулахад шаардагдах 103500 / Нэг зуун гурван мянга таван зуун / төгрөгийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зохих зардлаас гаргахыг нягтлан бодогч / М.Мөнхжаргал /-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Х.ЦОГЦЭЦЭГ


Нийслэлийн Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 27 дугаар сарын 25-ний өдрийн 116 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	Б.Гэрэлмаа	Хурлын төлөөлөгч, нийгмийн бодлого төлөвлөлтийн хорооны дарга, 1 дүгээр хорооны Засаг дарга
Нарийн бичгийн дарга:	Ё.Гэрэлцэцэг	Засаг даргын Тамгын газрын Тохижилт худалдаа үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	М.Өсөхдэлгэр	Хурлын төлөөлөгч, 2 дугаар хорооны Засаг дарга
	О.Энхмэнд	Цагдаагийн хэлтсийн хэв журмын ахлах
	Т.Ичинноров	Онцгой байдлын хэлтсийн ахлах байцаагч
	Ц.Зуунчимэг	Мэргэжлийн хяналтын тасгийн ахлах байцаагч
	С.Өлзийсайхан	Онцгой байдлын хэлтсийн байцаагч
	Т.Ариунболд	Хурлын Ажлын албаны мэргэжилтэн

Нийслэлийн Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 7 дугаар сарын 25-ний өдрийн... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД  
ШААРДАГДАХ ЗАРДАЛ

2018 оны 7 дугаар сар 31

Багахангай

Д/д	Шаардагдах материал	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хянасан
1	Шатахуун	50	1900	95000	
2	Масло	1	8500	8500	
Нийт дүн				103500	

ХЯНАСАН:  
НЯГТЛАН БОДОГЧ

М.МӨНХЖАРГАЛ

ТӨСӨВ ХИЙСЭН:  
МЭРГЭЖИЛТЭН *о.о.о*

Т.АРИУНБОЛД